

НИЙГМИЙН АЖИЛ-НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛАЛ

ҮЕ ДАМЖСАН ЯДУУРАЛ БА КРИСТИНА НОБЛИЙН ХҮҮХДИЙН САНГИЙН БОЛЗОЛТ МӨНГӨН ТУСЛАМЖИЙН ХӨТӨЛБӨР

*Б. Бат-Өлзий
Доктор (Ph. D.), дэд профессор*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

bbatulzii04@gmail.com

*Б. Байгалмаа
Магистрант*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

baigalmaa@snf.mn

Хураангуй: 1990 оны нийгмийн өөрчлөлтийн дараа “ядуурал” хэмээх нийгмийн үзэгдэл тулгамдсан асуудал болон гарч ирсэн билээ. Ядуурлын эсрэг төр, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллага, сайн санаат иргэдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь халамж дээр суурилсан, ихэвчлэн анхдагч хэрэгцээ буюу хоол хүнс, хувцас, гэр, орон байраар хангах, мэргэжлийн сургалтанд хамруулах, ажлын байранд зуучлах зэрэг үйлчилгээнүүдээр хязгаарлагдаж ирсэн байдаг. Эдгээр нь нэн тэргүүний арга хэмжээ мөн боловч урт хугацаанд ийнхүү “гал унтраах” арга хэмжээ авч ирсэн нь ядуурал буурахгүй байх үндсэн шалтгаан болсон. Өөрөөр хэлбэл дээрх үйлчилгээнүүд нь ядууралд өртсөн өрх, иргэний дутагдлын хэрэгцээн дээр нь түлхүү анхаарч, өсөлт хөгжлийн хэрэгцээг нь орхигдуулаад байсан учраас ядуурал үндсээрээ устах үйл явц удаашран, үе дамжих хандлага ихсэж байна.

Монгол улсад ядуу таван хүн тутмын хоёр нь 15-аас доош насны хүүхэд байна. Ядуу давхаргын хүмүүсийн ихэнх нь дунд буюу ахлах ангийн боловсролоос цааш суралцаагүй, тэдний аравны нэг нь л дээд боловсролтой байна.¹ Монгол Улсын нийт хүн амын гуравны нэг нь хүүхдүүд бөгөөд ойрын жилүүдэд залуучууд олноороо ажиллах хүчинд нэгдэх тул хүүхэд, залуучуудын хөгжилд хөрөнгө оруулж, ур чадварыг нь сайжруулах, мэргэжил, боловсролтой ажиллах хүчийг хөдөлмөрийн салбаруудад бэлдэж гаргах нь Монгол Улсын цаашдын хөгжилд болон ядуурлын хувь хэмжээг багасгахад өндөр ач холбогдолтой юм.

Түлхүүр үгс: Ядуурал, хүүхэд, боловсрол, чанартай үйлчилгээ, нийгмийн халамж

УДИРТГАЛ

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д “Монгол улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно” гэсэн зорилт тавьсан байдаг².

Гэвч үндэсний хэмжээнд ядуурал 2018 онд 28.4 хувьтай байгаа ба хүн амын 15 хувь ядуурлын шугамаас дөнгөж дээгүүр амьдарч, гэнэтийн хямралт үйл явдлын нөлөөгөөр ядууралд орох өндөр эрсдэлд байна.

Монгол улс 1990 оноос хойш тодорхой хэмжээгээр эдийн засгийн өсөлтийг хангаж, хүн амын боловсролын түвшинг өндөрт байлгаж, ядуурлыг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ирсэн. Үүний үр дүнд нэг хүнд ногдох ҮНО 2010 онд 1945 ам.дол байсан бол 2019 онд 3751 ам.дол болж өссөн³. Гэвч ядуурал буурахгүй байна.

Монгол Улсын эдийн засаг өсөж байгаа хэдий ч үр шим нь өрхийн, ялангуяа ядуу иргэдийн амьжиргааны түвшинд дорвитой нөлөөлөхгүй байна. Хөдөлмөрийн насны хүн амд (15+) ажилгүй, эдийн засгийн идэвхгүй хүмүүс хамгийн ядуу байна. Хүний капиталын түвшин доогуур байдаг

ядуу хүн амын хувьд хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг хангаж хангалуун цалинтай ажилд орох магадлал хомс тул ажилгүй хүн амын 40 хувь, эдийн засгийн идэвхгүй хүн амын 34 хувь нь ядуу байна. Хөдөлмөр эрхэлдэг хүн амд ядуу таван ажилчин тутмын гурав нь мэргэжил, ур чадвар бага шаардах энгийн ажил, хөдөлмөрийн хөлс багатай үйлчилгээний ажлууд эрхэлж байна⁴ (ҮСХ, ДБ).

Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсвэл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэдэг (<https://www.legalinfo.mn/law/details/393>). Аль ч улсын нийгмийн халамжийн тогтолцоо нь иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулан, нийт иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршдог. 2018 онд Монгол Улс нийгмийн халамжийн хөтөлбөрт 675.4 тэрбум төгрөг баталснаас 647.9 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангийн зардалд зарцуулсан байдаг. Нийгмийн халамжийн олон нэр төрлийн үйлчилгээнээс ядуу иргэдэд очдог халамжийн том дэмжлэг нь хүнсний талон олгох хөтөлбөр

болон хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрүүд байдаг. 2018 онд хүнсний талон 288,700 гаруй иргэнд 42,2 тэрбум төгрөгийг, хүүхдийн мөнгөн тусламжинд (0-554 оноотой) 684,000 гаруй хүүхдэд 164.2 тэрбум төгрөгийг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 76,400 иргэнд 23.1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна. (<https://mof.gov.mn/article/entry/CITIZENBUDGET-30>).

Нийгмийн халамжийн дээрх хөтөлбөр, арга хэмжээнүүд нь ядуурлыг бууруулахад чиглэгдэж байгаа ч статистик үзүүлэлт болон бодит амьдрал дээр ядуурлын хувь хэмжээ буурахгүй, иргэд орлогын төдийгүй сэтгэлгээний ядууралд улам бүр нэрвэгдэж, ядуу амьдралт, хувь заяатайгаа эвлэрч, түүнээс гарах эрмэлзлээсээ няцах хандлагатай болж байгаа нь хөдөлмөр эрхлэн, амьдралаа авч явах боломжтой боловч халамж хүртэх сонирхолтой, хүртээд явж байгаа иргэдийн талаарх судалгааны баримтуудаас харагдаж байна. *(ХХҮЕГ, ООТА-аар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа, 2017, амьжиргааны түвшний доод бүлгийн өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлээгүй болон ажиллах хүчнээс гадуур гэсэн үр дүнгээр хамгийн өндөр буюу 66.7 хувьтай байна)*

Тиймээс судлаачийн хувьд нийгмийн халамжийн үйлчилгээг нийгмийн хөгжлийн үйлчилгээтэй уялдуулан хүргэх, өрх иргэнд

халамжийн үйлчилгээг тодорхой хугацаатай, ямар нэг нөхцөл, болзолтой болгох шинэ арга хэлбэрт шилжих шаардлагатай гэж үзэж байна. Түүнчлэн ядуурлыг бууруулах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүүхэд залуучууд руу чиглэсэн тогтвортой хөгжлийн бодлого, тэднийг хөдөлмөрийн зах зээл дээр үнэлэгдэх хэмжээний ур чадвартай, мэргэжил, боловсролтой болгож бэлтгэх явдал чухал юм.

Дээрх хэрэгцээ шаардлагын дагуу ядуу иргэд рүү чиглэсэн халамжийн үйлчилгээг хөгжлийн үйлчилгээтэй уялдуудан үр дүнтэй хэрэгжүүлж буй “Кристина Ноблийн Хүүхдийн Сан”-ийн туршлагын судлан үзэж, жишиг болгон авч үзлээ.

ОНОЛ, АРГА ЗҮЙ

Сүүлийн 30-аад жилд манай улсад ядуурлыг бууруулах чиглэлээр Засгийн газар болон Олон улсын хандивлагч байгууллагаас шат дараатай, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Гэсэн ч ядуурал, ажилгүйдэл дорвитой буурахгүй, орлогын тэгш бус байдал улам нэмэгдсээр байгаа нь эдийн засгийн эрчимтэй өсөлтийн үр шим ард иргэдэд жигд хүртээмжтэй хүрч чадахгүй байгааг харуулж байна.

Эдийн засаг, ядуурал хоорондын хамаарлыг судласан олон улсын нилээдгүй судалгаа байдаг боловч харилцан адилгүй үр дүн гарсан байдаг. Жишээ нь

Энэтхэг, Филиппин улсад 1970-1990 онд эдийн засаг өсөхөд ядуурал буурсан, харин Тайланд, Малайз, Шриланка улсад 1980-1990 онд эдийн засаг өсөхөд ядуурал өссөн байна (AlNabees ба Rumman, 2012).

Монгол улсад энэ чиглэлээр хийсэн судалгааны үр дүнгүүдээс харвал: Эдийн засгийн өсөлт нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлдэг, ингэснээр өрхийн орлого өсөж ядуурлыг бууруулдаг, гэхдээ нөгөө талдаа эдийн засгийн өсөлт нь инфляц хөөргөх шалтгаан болдог, ингэснээр өрхийн худалдан авах чадвар буурч, ядуурлыг бууруулахад саад болдог (Лхам, 2008; Батмөнх болон бусад, 2010), Эдийн засгийн өсөлт нь ядуурлыг бууруулахад нөлөөлдөггүй. Учир нь эдийн засгийн өсөлт нь нийгмийн халамжийг нэмэгдүүлдэг, нийгмийн халамж өссөн нь ядуурлыг бууруулах бус, эсрэгээрээ өсгөх нөхцөл болдог (Азийн хөгжлийн банк, 2011), Эдийн засгийн өсөлт нь Монгол Улсад шингэдэггүй, өсөлтийн ихэнх нь гадагш урсдаг, мөн баялгийн хуваарилалтын тэгш бус байдал нэмэгдсэнээс шалтгаалж эдийн засгийн өсөлт нь ядуурлыг бууруулахад нөлөөлдөггүй (Амартүвшин болон бусад, 2012) гэжээ.

Дэлхийн банкны судалгаагаар эдийн засгийн өсөлт нь ядуурал бууруулах үндсэн нөхцөл мөн, гэхдээ энэхүү өсөлтийг үр дүнтэй хэрхэн ашиглаж чадах эсэхээс ядуурлыг бууруулах нь

шалтгаална гэжээ. Хөгжиж буй орнуудын тухайд ядуурлыг бууруулах хамгийн үр дүнтэй арга нь эдийн засгийн өсөлтийг хүний хөгжилд буюу нэн ялангуяа боловсрол, эрүүл мэндэд түлхүү ашиглах нь зүйтэй гэж үздэг (Al-Nabees ба Rumman, 2012). Иймд манай улсын хувьд ядуурлыг тууштай бууруулахын тулд эдийн засгийн эрчимтэй өсөлтийг ард иргэдийн боловсрол, эрүүл мэндэд түлхүү ашиглах шаардлагатай байна.

1990-ээд оноос эхэлсэн зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед эдийн засгийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой ажилгүйдэл, бодит орлогын бууралт, нийгмийн хамгааллын системийн өөрчлөлт зэргийн улмаас хүн амын амьжиргааны түвшин буурч байсан. Тухайн үеийн ядуурал нь орлогын ядуурал буюу нөхцөл байдлаас хамаарсан ядуурал (situational poverty) байсан ба иргэд хэдий ядууралд өртсөн ч тэдний өмнөх нийгмээсээ авсан боловсрол, эрүүл мэнд, хандлага төлөвшил зэрэг амьдрах чадавхийн хүчин зүйлсүүд нь хадгалагдан үлдэж байсан. Гэвч эдгээр хүмүүсийн үр хүүхэд буюу дараагийн үе нь хомсдлын тойргоосоо гарах чадамжгүй, ядуу нөхцлөөс шалтгаалан бий болсон үе дамжсан ядуурлыг бий болгож байна.

Бие хүний хэрэгцээний талаар хамгийн энгийн ойлгомжтой тайлбарласан А.Маслоугийн хэрэгцээний шаталсан онолд хүний

бүх хэрэгцээг таван түвшинд ангилан хуваасан ба үүнийгээ АНХДАГЧ болон СОЁЛЫН хэрэгцээнүүд гэж тоймлосон байдаг. Энэ онолын тайлбарлалаар анхдагч хэрэгцээ хангагдсаны дараа, дараагийн түвшний соёлын хэрэгцээ бий болох боломжтой гэж үздэг. Тиймээс ядуурлыг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ учир, шалтгаанд нь үндэслэн ултай суурьтай арга хэмжээг авч ажиллах буюу хүний дутагдлын хэрэгцээн дээр тулгуурлан цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

СУДАЛГАА

1990 оны нийгмийн шилжилтийн дараах хүнд цаг үед буюу 1997 оноос Кристина Ноблийн Хүүхдийн Сан Монгол Улсад үйл ажиллагаагаа эхлүүлсэн байдаг. 1998 онд Монголын нийт хүн амын 35.6 хувь нь ядуу, үүнээс 19.7 хувь нь нэн ядуу (“Хүн амын амьжиргааны түвшний судалгаа”, 1998) амьдарч байсан статистик үзүүлэлт байдаг.

Сангийн үүсгэн байгуулагч хатагтай Кристина Ноблийн үндсэн үзэл санаа болох “*First you feed a child’s stomach, then you feed their spirit*” буюу “*эхлээд хүүхдийн гэдсийг цатга, дараа нь түүний сэтгэлийг цатга*” хэмээх гол зарчим дээр тулгуурлан Монгол улсын зорилтот бүлгийн хүүхэд болон тэдний гэр бүлд удаан хугацааны нийгэм, сэтгэлзүйн дэмжлэг тусалцааг үзүүлэн хүүхдийн

хөгжил, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Хүүхдийн сайн сайхан бол тухайн нийгмийн сайн сайхны илэрхийлэл байдаг. Тиймээс ядуурлыг устгах, тэгш ирээдүйг бий болгохын тулд хүүхдэд хөрөнгө оруулалт хийх нь нэн чухал юм гэж үзэж байв.

Тус сангийн ядуурлыг бууруулах, тэр дундаа үе дамжсан ядуурлаас сэргийлэхэд туршлага болохуйц нэгэн хөтөлбөрийн талаар судалсан судалгааны үр дүнг энэ өгүүлэлдээ авч үзэж байна.

Хүүхэд Ивээн Тэтгэх хөтөлбөр: Бэлэн мөнгөний тусламж олгох хөтөлбөр нь урт, богино хугацаанд хүүхэд, түүний гэр бүлийг дэмжин, өрхийн суурь хэрэгцээ буюу хоол хүнс, хүүхдийн боловсрол, хөгжил, эрүүл мэндэд зарцуулагддаг тул энэхүү дэмжлэг нь эцэг эхэд ирэх ядууралтай холбоотой сэтгэлзүйн дарамтыг багасгах, гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүүхэд хүмүүжлийн эерэг байдал бий болоход тустай байдаг байна. Бэлэн мөнгөний бодитой, тогтмол тусламж нь хүүхдийн эрүүл мэнд, бие махбодь, сэтгэлзүйд эерэгээр нөлөөлөн, тасралтгүй суралцах, боловсрол эзэмших, даван туулах чадварыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой ажээ. Цаашлаад хүүхдээр дамжуулан ядуурлын тойргийг таслах, ирээдүйд хүчирхийллээс ангид, биеэ даасан иргэнийг төлөвшүүлэх зорилготой хөтөлбөр юм. Хөтөлбөрт хүүхэд дунджаар 8-10 жилийн урт

хугацаанд буюу Их дээд сургууль, коллеж төгсөж, мэргэжил боловсролтой, нийгэм, сэтгэлзүйн хувьд биеэ даан амьдрах чадвартай иргэн болтлоо хамрагддаг.

Хөтөлбөрийн хүрээнд сар бүр бэлэн мөнгөний тусламж хүүхдэд олгогддог ба энэ нь гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэх үйл ажиллагааны хөшүүрэг болох дам зорилготой.

Хөтөлбөрийн үндсэн зорилго нь:

- Хүүхдийг эрүүл, боловсролтой, нийгэм, сэтгэлзүйн хувьд биеэ даасан иргэн болгож хүүхдээр дамжуулан ядуурлыг устгах;

- Гэр бүлийг дэмжих, хөгжүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан ядуурлаас гаргах явдал юм.

Хэдийгээр уг хөтөлбөр нь бэлэн мөнгө өгч байгаагаараа бусад хөтөлбөрүүдээс ялгаагүй мэт боловч, хөтөлбөрт хүүхэд болон гэр бүлийг хамруулахдаа тусгай нөхцөл тавьж, хяналтыг байнга хийдэг нь тусламж үр дүнтэй зарцуулагдах, хүүхэд гэр бүлд тэр хэмжээгээр эерэг үр дүн гарах үндэс болдог. Гэр бүлд буюу эцэг, эх, хүүхдэд тавьж буй тусгай нөхцөл болзол нь энэ хөтөлбөрийн амжилттай хэрэгжих, тавьсан зорилгодоо хүрч ядуу гэр бүлийг ядуурлаас гаргах, үе дамжсан ядуурлаас сэргийлэх, дээшилж дэвжих бололцоог олгодог байна.

Үйлчилгээний интервенци бүр хүүхэд, гэр бүлийн онцлогт

тохирсон амьдралын чанарыг дээшлүүлэх тусгай төлөвлөгөөний дагуу тавигдах өөр өөр нөхцөлтэй боловч нийтлэг гэр бүлийн гишүүдийн хандлагыг өөрчлөх зорилготой хэд хэдэн нөхцлийг заавал тавьдаг:

1. Тухайн гэр бүлийн хүүхэд нэг бүр хичээл, сургуульд заавал хамрагдсан байх. Хичээл сургуулийн ирц, сурлагын чанар дээр эцэг эх, асран хамгаалагч байнга хяналт тавих.

2. Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс орлогоо нэмэгдүүлэх, амьдралын чанараа дээшлүүлэх үйл ажиллагааг тогмол хийх, үйл явцаа тайлагнадаг байх.

3. Хүүхдүүдийн эрүүл мэнд, ариун цэвэрт тогтмол анхаарах, амьдарч буй орчны ариун цэвэр, тохижилтонд анхаарч байх.

4. Хүүхдийн хажууд архидан согтуурах, тамхи татах, зүй бус харилцаанд орох, хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахгүй байх.

5. Хүүхэд болон гэр бүлийн гишүүд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалт, семинар нөлөөллийн ажилд заавал оролцох, ирцээ бүртгүүлэх.

6. Гэр бүлийн амьдралын чанарт болоод хүүхдүүдийн сурлагын чанарт эерэг өөрчлөлт гарсан тохиолдолд мөнгөн тусламжийг нэмэгдүүлэх, гэрийн орчин нөхцлийг сайжруулах тал дээр дэмжлэг үзүүлэх, хүүхдийн дээд боловсрол эзэмших, их дээд сургуульд суралцахад дэмжлэг

үзүүлэх зэрэг болзол, нөхцлийг тавьсанаар хүүхэд болон гэр бүлийн гишүүдийн хариуцлага нэмэгдэн, уламжлалт халамжийн тогтолцоо буюу зүгээр суусан ч халамжлуулдаг байдлыг халсан шинэ туршлага юм.

Ажилгүй орлогогүй гэр бүлийн хувьд нэмэлт мөнгөн тусламжинд хамрагдах нь маш чухал асуудал байдаг нь хөтөлбөр хэрэгжсэн олон жилийн туршлагаас харагддаг. Тиймээс уг тусламж нөхцөлтэй байх нөхцөлгүй байхаас үл хамаараад иргэд аль болох хамрагдах хүсэлтэй байдаг. Тэд ямар ч аргаар хамаагүй нэмэлт тусламж дэмжлэгэнд хамрагдах сонирхолтой байдаг давуу тал дээр нь тулгуурлан халамжийн тусламж үйлчилгээнүүдийг нөхцөлтэй болгох нь халамж хүртэгч талын амьдралын чанарт болон халамжийн үйлчилгээг хүргэж буй талын ажлын үр дүнд чухал ач холбогдолтой нь харагдаж байна.

Хөтөлбөрийн гол үр шим хүртэгч нь хүүхэд бөгөөд Хүүхэд Ивээн Тэтгэх Хөтөлбөрт нэг хүүхэд дунджаар 8 жил хамрагддаг ба жилд дунджаар 1000 орчим хүүхэд болон тэдний гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг. Сар бүрийн нэмэлт мөнгөн тусламжийн үйлчилгээнээс гадна эрүүл мэнд, сэтгэлзүй, боловсрол, хөгжил, оролцоог дэмжсэн тусгай төсөл хөтөлбөрүүдэд хүүхдүүд болон гэр бүлийн гишүүд хамрагддаг байна. Жил бүр ойролцоогоор 100 орчим хүүхэд болон тэдний гэр бүл тус

хөтөлбөрөөс амжилтай төгсөн гардаг.

Хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээний үндсэн 2 үзүүлэлт бий:

1. Тухайн өрхөөс хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн хувийн өсөлт хөгжил буюу тодорхой мэргэжил, боловсрол эзэмшсэн байдал ба биеэ даан амьдрах чадамж;

2. Гэр бүлийн амьдралын ерөнхий нөхцөл байдал сайжрах буюу амьжиргааны түвшин тогтоох үнэлгээний дундаж оноо руу орох.

Тухайлбал 2017, 2018 оны байдлаар нийт хөтөлбөрт хамрагдсан хүүхэд тэдний гэр бүлийн гишүүдээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 4902 хүн, Боловсролын тэтгэлэгт 99 оюутан, хүүхдийн дугуйлан секцэнд 634, сар бүрийн ивээн тэтгэлгийн мөнгийг 1060 хүүхэд, нийт 23 гэр бүлийн 129 хүнд 5 ханатай, иж бүрэн тавилгатай гэр олгосон ба сургалт нөлөөллийн ажилд нийт 3387 хүнийг хамруулсан байна.

Хөтөлбөрийн үр дүнг тооцож үзэхэд нийт хөтөлбөрийг төгсөн гарсан хүүхдүүдийн 35% нь МСҮТ, Коллеж, 65% нь Их дээд сургуулийг амжилттай төгсөж, хүүхдүүдийн 80% нь ажлын байртай болж, тогтмол орлоготой болсон ба 15% нь гадаад улс орон руу сурах болон ажиллах зорилгоор явсан байна.

Хөтөлбөрт хамрагдсан өрхийн 85% нь халамжийн үйлчилгээнээс хөдөлмөрийн зах зээл рүү шилжсэн буюу өрхийн орлогын дийлэнх хувь нь хөдөлмөр

эрхлэлтийн орлогоос бүрдэх болсон байна. Хөдөлмөрийн насны гишүүдийн 70% нь тогтмол байнгын ажлын байртай болсон байв. Ман суурь боловсрол эзэмших насны хүүхдүүд 100% сургуульд хамрагдсан.

Өрхийн гишүүдийн нийгмийн идэвх, санаачилга нэмэгдэж, сөрөг зан үйл арилж гэр бүлийн харилцаа эерэг, таатай болсон байсан. Нийт өрхийн амьжиргааны түвшин өмнөх үеэсээ (2 жилийн өмнөх) дээшилж, өрхийн хөгжлийн түвшинрүү ахисан байсан ба төрөөс үзүүлдэг халамжаас авдаг хүнсний тусламжийн үйлчилгээнээс 40% нь хасагдсан байсан.

Хүүхдийн хүмүүжил, халамж, асаргаанд зарцуулдаг эцэг эхийн цаг өмнөх жилүүдээс 50-аас дээш түвшинд нэмэгдсэн. Нийт өрхийн 85% нь эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан орчинд амьдарч байна.

ДҮГНЭЛТ

Хөтөлбөрт хүүхэд болон гэр бүлийг хамруулахдаа урьдчилан нөхцөл болзлын талаар мэдээлэл хүргэн харилцан зөвшилцсөний үндсэн дээр хамруулдаг тул эцэг эх асран хамгаалагчид болон бусад гэр бүлийн гишүүд өөрсдийн хүлээсэн үүрэг хариуцлагаа харьцангуй ухаарч ойлгосон байна. Тухайн гэр бүл, хүүхдийг хариуцсан нийгмийн ажилтан байнгын харилцаа холбоотой байж, сар бүр уулзалт хийж гэр бүл дээр гарч буй ахиц

дэвшил болон хүүхдийн хичээл сургуулийн үйл явцтай танилцан хяналт тавьдаг тул эцэг эх нь амьдралаа сайжруулах талаар бодол, төлөвлөгөөг гаргах болж, ямар нэгэн идэвхитэй үйл ажиллагаа хийж эхэлдэг нь тухайн хөтөлбөрийн давуу тал юм.

Өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд олон талын оролцоотой мэргэжлийн үйл ажиллагаа шаардлагатай бөгөөд өрхийн гишүүдийн анхдагч хэрэгцээ болох хоол, хувцас, түлээ нүүрс хичээлийн хэрэглэл зэрэг тусламж үзүүлэн, ар гэрийн орчин нөхцлийг сайжруулан гэрийн тусламж олгосноор өрхийн гишүүдийн сэтгэл санаа тайвширч амьдралынхаа талаар эргэцүүлж бодох, дараагийн амьдралын төлөвлөгөөгөө гаргах, оюун санаа болон амьдрах ухааны чадвар дээрээ анхаарах боломжтой болдог нь анаарагдсан. Анхдагч хэрэгцээндээ санаа зовохоо больсон хүн хүүхдийнхээ хүмүүжил, боловсрол, сэтгэл санааны байдалд анхаарах сэтгэлзүй нь бэлэн болдог аж. Тиймээс тус хөтөлбөрийн хүргэж байгаа тусламж нь зорилтот гэр бүлд хамгийн хэрэгцээтэй, чухал тусламж бөгөөд тухайн хэрэгцээг хангасны дараа гэр бүл дээр хөгжлийн болон амьдралын чанарыг дээшлүүлэх төлөвлөгөөг гарган ажилласан нь үр дүнтэй болсон байна.

Төрөөс ядуурлыг бууруулах, зорилтот гэр бүлийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг үр дүнтэй

хэрэгжүүлэхэд хэд хэдэн саад бэрхшээл байдаг нь нэг мэргэжилтэнд ноогддог өрх, иргэдийн тоо хэмжээ олон, нөгөө талаар халамжийн мэргэжилтэн болон хөгжлийн нийгмийн ажилтан хоёрын ажил үүрэг уялдаагүй, төсөв санхүү нь тусдаа, үйлчилгээнд хамрагдаж буй өрх бүр нэг бүрт анхаарал хяналт тавих санхүүгийн болон бусад нөөцөөр хязгаарлагдмал зэрэг олон шалтгаанууд байдаг. Тиймээс төр болон төрийн бус, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, зарим нэг үйлчилгээг төр заавал өөрөө гүйцэтгэхгүй мэргэжлийн, туршлагатай төрийн бус болон олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх нь үр дүнтэйг дээрх хөтөлбөрийн туршлага харуулж байна.

НОМ ЗҮЙ

1. Дэлхийн банк веб сайт <https://www.worldbank.org/mn/news/press-release/2019/06/21/mongolias-2018-poverty-rate-estimated-at-284-percent>
2. Хуулийн нэгдсэн портал сайт <https://www.legalinfo.mn/law/details/11710>
3. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо <https://www.1212.mn/>
4. Сангийн яам портал сайт https://mof.gov.mn/article/entry/CITIZE_NBUDGET-30
5. Хөдөлмөр халамжийн ерөнхий газар <http://hudulmur-halamj.gov.mn/>
6. <https://www.worldbank.org/mn/news/press-release/2019/06/21/mongolias-2018-poverty-rate-estimated-at-284-percent>
7. <https://abcnews.go.com/WNT/International/story?id=1350000>.
8. <http://documents.worldbank.org/curated/en/643291468190773930/pdf/99518-WP-World-bank-group-Box393201B-PUBIC-mongolian.pdf>
9. <https://www.cncf.org/report/>